

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар: 08

Улаанбаатар хот

**Бодлогын баримт бичиг
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.6.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.4.2.6.ж, 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.


2. “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо (С.Мөнхтөр)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ



ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үндэсний давхар даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн хэмжээнд цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг энэ баримт бичгээр тодорхойлно.

1.2. Энэ баримт бичиг нь компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Компани цалин, урамшууллын бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

1.3.1. Ижил үнэлэмж бүхий ажил хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох;

1.3.2. Цалин, урамшууллын хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх;

1.3.3. Цалин, урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох;

1.3.4. Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах;

1.3.5. Ажиллагсдын цалин, урамшууллыг шударга хуваарилах, ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх.

Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо (цаашид “Хороо” гэх) нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах ба цалин, урамшууллыг дараах хэлбэрээр олгох бодлого хэрэгжүүлнэ:

2.1.1. Тогтмол цалин;

2.1.2. Хуралд оролцсон цалин;

2.1.3. Компанийн хагас жил, жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгох нэмэлт цалин болон мөнгөн урамшуулал;

2.1.4. Мэргэжлийн, өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай хэмжээний цалин, урамшуулал;

2.1.5. Компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн мөнгөн урамшуулал.

2.2. Хороо нь энэ журамд заасантай нийцүүлэн компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудын цалин, урамшууллын талаар санал боловсруулж ТУЗ-д танилцуулах, ТУЗ-өөс баталсан цалин, урамшууллын бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах байдлаар цалин, урамшууллын бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3. Хороо нь компанийн цалин, урамшуулалтай холбоотой дүрэм, журмын үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар санал, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна.

2.4. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох асуудал нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг Засгийн газар, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон хэмжээнээс ихгүй тогтооно.

2.5. Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын хэмжээг Засгийн газар, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэр, энэ баримт бичигт нийцүүлэн ТУЗ шийдвэрлэнэ.

2.6. Компани нь ажилтнуудад олгох цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс зэрэг цалин хөлстэй холбогдох зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, хэрэгжилтийг нь хангаж ажиллана.

2.7. Энэ баримт бичигт нийцүүлэн компанийн ажилтнуудын цалин, урамшууллын хэмжээг гүйцэтгэх удирдлага тогтооно.

Гурав. Бусад зүйл

3.1. Хороо нь энэ баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавина.

3.2. Энэ баримт бичгийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг компани хариуцна.

3.3. Компани энэ баримт бичигт тусгагдаагүй цалин, урамшуулалтай холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

3.4. Компанийн гүйцэтгэх удирдлага энэ баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.5. Энэ баримт бичгийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.



---oOo---